| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,803,583,600.00 | 2,607,951,677.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,633,996,400.00 | 2,455,084,335.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,589,165,600.00 | 2,414,058,649.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,922,988,900.00 | 1,861,063,246.31 |
| 210101 | Үндсэн цалин | 1,423,274,100.00 | 1,403,596,348.31 |
| 210102 | Нэмэгдэл | 348,038,300.00 | 322,167,156.00 |
| 210104 | Урамшуулал | 151,676,500.00 | 135,299,742.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ** | 241,951,200.00 | 233,557,107.38 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 165,057,200.00 | 160,124,186.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,069,000.00 | 18,781,546.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,725,800.00 | 14,367,670.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,702,800.00 | 4,160,248.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,396,400.00 | 36,123,455.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 133,271,200.00 | 106,791,341.10 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,874,600.00 | 28,032,993.10 |
| 210302 | Түлш, халаалт | 88,146,800.00 | 78,010,048.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,249,800.00 | 748,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,590,100.00 | 43,979,795.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,908,300.00 | 7,695,436.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,772,600.00 | 19,674,498.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,318,200.00 | 4,318,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,058,100.00 | 1,148,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а | 5,203,100.00 | 2,478,667.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,329,800.00 | 8,664,694.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 140,338,100.00 | 74,638,611.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,168,700.00 | 600,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 134,074,900.00 | 71,944,311.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,094,500.00 | 2,094,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27,489,500.00 | 26,114,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,737,900.00 | 9,737,900.00 |
| 210602 | Тавилга | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,751,600.00 | 6,376,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,653,100.00 | 8,649,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,881,300.00 | 5,878,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,771,800.00 | 2,771,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | 6,978,800.00 | 6,912,515.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил | 3,779,000.00 | 3,712,870.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,320,000.00 | 1,320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 889,200.00 | 889,125.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 510,600.00 | 510,520.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 330,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 150,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,904,700.00 | 52,352,233.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,221,200.00 | 47,931,533.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,683,500.00 | 4,420,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,830,800.00 | 41,025,686.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,830,800.00 | 41,025,686.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,402,500.00 | 26,747,386.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэм | 8,882,800.00 | 8,882,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,545,500.00 | 5,395,500.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **169,587,200.00** | **152,867,342.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 169,587,200.00 | 152,867,342.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 169,587,200.00 | 152,867,342.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,803,583,600.00 | 2,662,273,145.29 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,888,907,800.00 | 1,750,828,809.57 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,888,907,800.00 | 1,750,828,809.57 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 838,894,000.00 | 800,658,651.22 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 675,206,800.00 | 636,971,451.22 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 163,687,200.00 | 163,687,200.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНА** | 75,781,800.00 | 110,785,684.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,100,000.00 | 41,560,548.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 2,471,760.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 74,681,800.00 | 66,753,376.50 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 65,053,516.60 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 119,374,984.60 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **389,208,581.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **289,659,230.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 48,909,230.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,448,400.00 |
| 210104 | Урамшуулал | 1,448,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,486,787.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,130,787.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 56,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,717,302.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,717,302.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 250,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 250,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12700000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,700,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22306741.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,317,801.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,988,940.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 240,750,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 240,750,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 240,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 750,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **99,549,351.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 99,549,351.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 99,549,351.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 389,208,581.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 389,208,581.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,969,193.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 377,952,992.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,286,396.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Ул сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Х.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 24–ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-Ул сум нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих жил

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Ул сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2020 онд Баян-Ул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Баян-Ул сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 2,632,250.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 52,645.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 2,472,461.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 49,449.2 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Уул сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,342.4 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 158,084.0 | 222,446.4 | 64,362.4 |
| Авлага | 217,249.0 | 168,302.3 | -48,947.0 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 377,385.4 | 357,045.7 | -20,339.7 |
| Үндсэн хөрөнгө | 12,207,124.1 | 13,204,183.5 | 997,059.4 |
| **Нийт хөрөнгө** | **12,959,842.6** | **13,951,977.6** | **992,135.0** |
| Өр төлбөр | 13,421.9 | 1,483.9 | -11,938.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 12,946,420.7 | 13,950,493.7 | 1,004,073.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **12,959,842.6** | **13,951,977.6** | **992,135.0** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 222,446.4 мянган төгрөг болж 64,362.4 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн татварын орлого давсан, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогын төвлөрүүлэлт нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Нийт авлага 168,302.3 мянган төгрөг болж 48,947.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд сум хөгжлийн сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл олгоогүй мөн зээлийн авлагын барагдуулалт хийснээс тус тус шалтгаалсан байна. Одоогоор нийт авлагын 99.0 хувийг буюу 168,302.0 мянган төгрөг нь тус сангийн авлага байна. Сангийн авлагаас 31,642.9 мянган төгрөгийн авлага нь хэвийн төлөлттэй, 113,840.3 мянган төгрөгийн 12 зээлдэгчидтэй холбоотой авлагыг шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт бөгөөд хугацаа хэтэрсэн 3 зээлдэгчийн 22,818.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажилбар хийгдээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 357,045.7 мянган төгрөг болж өмнөх оноос 20,339.7 мянган төгрөгөөр буурсан нь шинээр бараа материалын худалдан авалт хийгдээгүй өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,342,886.4 мянган төгрөг болж 1,462,312.9 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа шинэ сум төсөл дуусч хүлээж авсан мөн бусад эх үүсвэрээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 5,569,181.8 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 21,198.6 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 15,945.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 5,701,320,3 мянган төгрөг, акталсан 30,341.7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 13,421.9 мянган төгрөг болж 11,938.0 мянган төгрөгөөр буурсан нь төлбөр тооцоо барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,946,420.7 мянган төгрөг болж 1,004,073.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Баян-Уул сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үр дүнгийн нийт орлого өмнөх оноос 4,703,007.5 мянган төгрөгөөр буюу 19.3 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 3,362,533.9 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь өмнөх оны үлдэгдлээс санхүүжилт төлөвлөж хөрөнгө оруулалт болон тоног төхөөрөмж, урсгал зардлуудыг буурснаас шалтгаалсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 785,529.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 785,529.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 34,641.0 мянган төгрөгөөр бууруулж 750,988.6 мянган төгрөгөөр баталсан байна

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,803,583.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,888,907.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 838,894.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,100.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 74,681.8 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Төсвийн бодит гүйцэтгэлээр нийт 2,662,273.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос улсын төсвөөс 1,750,828.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 110,785.6 мянган төгрөг,орон нутгийн төсвөөс 800,658.6 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч, 138,078.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 33,297.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,607,951.7 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 70,319.8 мянган төгрөгөөр, байр ашиглалт, тогтмол болон бусад зардлыг 26,479.9 мянган төгрөгөөр бусад зардлыг 98,832.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Баян-Уул сум нь 2020 онд 90,390.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 133,187.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 147,3 хувиар биелүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,969.2 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 377,953.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,286.4 мянга, нийт 389,208.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ерөнхий боловсролын сургуульд 7,453.9 мянга, соёлын төв 356.0 мянга, Засаг даргын тамгын газарт 140,398.7 мянга, иргэдийн төлөөлөгчийн хуралд 241,000.0 мянга, нийт 389,208.6 мянган төгрөгийг 100 хувь зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 149 мэдээлэл байршуулбал зохих байснаас нийт 138 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн, орон нутгийн хөгжлийн сангийн 2 дугаар сарын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийн нийт 108,300.0 мянган төгрөгийн мэдээлэл болон мөнгөн дүнгүй 10 мэдээлэл хуулийн хугацааг хоцроон байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 27,950.6 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгах 2,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 25,950.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 2* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 2,000.0 | 1 | 2,000.0 | 0 | 0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 25,950.6 | 2 | 25,950.6 | 0 | 0 | 100 |
| Нийт дүн | 3 | 27,950.6 | 3 | 27,950.6 | 0 | 0 | 100 |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,337.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,697.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 37,640.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 24,697,999 төгрөгийн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт болон сум хөгжлийн сангийн авлага барагдуулалттай холбоотой зөрчилд 2 албан шаардлага, сум хөгжлийн сангийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдсэн тул тайлант онд иргэдэд хөнгөлөлтэй зээлийг зохих журмын дагуу олгоогүй болон санхүүгийн тайланд устгах бичилт хийх талаар 2 зөвлөмж хүргүүллээ.

1. Тайлант онд сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг захирамжтай тулган шалгахад Засаг дарга нь тайлант онд захирамжаар 44,5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 14,8 сая төгрөгийн 12 захирамж нь Төсвийн тухай хуулийн 27.1.1-т "төсвийн зарчмыг мөрдлөг болгох", 27.4.4-т "хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага", Сангийн Сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалын 1.2, 2.1 дэх заалтуудтай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

2. Сум хөгжлийн сангийн зээлийн хугацаа хэтрэлттэй 3 зээлдэгчийн 22,8 сая төгрөгийн авлага байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмын 1.6.2-т “Зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна.” гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн санхүүгийн тайлангийн устгах бичилттэй холбоотой болон тайлант онд иргэдэд хөнгөлөлтэй зээлийг зохих журмын дагуу олгоогүй зэрэгт 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сумын нийт дотоод устгалын дүн нь 781,307,868.28 төгрөг бөгөөд дээрх устгалыг бүрэн хийсэн байна. Харин орлого, зардлын нийт 884,327,680.04 төгрөгийн гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахаар төлөвлөсөн байна. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тус устгалын бичилтийг анхаарч үзье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

*Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлттэй холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:* Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн орлого, зардлын гадаад устгалыг аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн тусгах.

*1.2 Эрсдэл*: Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.

*1.3 Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

*1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

*Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

*2.1 Илрүүлэлт: Сум хөгжлийн сангийн үлдэгдэл нь сангийн хөрөнгийн нийт үлдэгдлийн 20 хувиас давж 94,4 сая төгрөг төвлөрсөн болович тайлант онд хөнгөлөлттэй зээл олгоогүй байна.*

*2.2 Эрсдэл*: Журам хэрэгжихгүй байх, хөрөнгийн эргэц удаашрах

*2.3 Өгсөн зөвлөмж:* Засгийн газрын 2016 оны 153 дугаар “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмын 1.11-т "Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурал тогтооно." Гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

*2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: **2020**

Аудитын нэр: ***Баян-Уул сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

Аудитын код: ДОА-2021/1/СТА-ТТ3

Шалгагдсан байгууллагын нэр: ***Баян-Уул сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан***

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа журамд нийцээгүй 14,821.2 мянган төгрөгийн захирамж гаргаж зарцуулсан байна. | 14,821.2 | Албан шаардлага | Засаг дарга | Х.Баттулга |
| 2 | Сум хөгжлийн сангийн хөрөнгөнөөс сумын 2 иргэд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхээр олгосон хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл 22,818.8 мянган төгрөгийн зээл одоог хүртэл барагдуулаагүй байна. | 22,818.8 | Албан шаардлага | Засаг дарга | Х.Баттулга |
| 3 | Тайлант онд нийт 149 мэдээлэл байршуулбал зохих байснаас нийт 138 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн, орон нутгийн хөгжлийн сангийн 2 дугаар сарын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийн нийт 108,300.0 мянган төгрөгийн мэдээлэл болон мөнгөн дүнгүй 10 мэдээлэл хуулийн хугацаагаар хоцроон байршуулсан байна. | 0 | Албан шаардлага | Засаг дарга | Х.Баттулга |
| 4 | Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь устгах бичилтийг бүрэн хийхэд анхаарч ажиллах. | 0 | Зөвлөмж | Засаг дарга | Х.Баттулга |
| 5 | Сум хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдэл журамд заасан хэмжээнд хүрсэн тул хөнгөлөлттэй зээлийг журмын дагуу олгоогүй байна. | 0 | Зөвлөмж | Засаг дарга | Х.Баттулга |
| 6 | Улзын хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 24,697,9 мянган төгрөгийн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн тул санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав. | 24,697.9 | Залруулга | Засаг дарга | Х.Баттулга |
| **ДҮН** | | **62,337.9** | | | |